

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БОУАС	Байгаль орчин уур амьсгалын сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОГДХАН УУЛЫН ДАРХАН
ЦААЗАТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА Д.БАТМӨНХ
ТАНАА

2020.02.27 № 06/621
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга Д.Батмөнх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн зарцуулалт, балансын данстай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 19-нөөс 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дөлгөөнхайрхан уул аудит ХХК-ийн аудитор Д.Дондог, аудиторовын туслах Д.Эрдэнэтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 84 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Богдхан уулын дархан цаазат газрын экологийн тэнцвэрт байдлыг

хадгалан, байгалийн нөөц баялгийн хамгаалалт, ашиглалтын менежментийг зүй зохистой явуулах, Монгол улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн болон Байгаль орчны багц хуулиудын хэрэгжилтийг хангахад оршино.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Богдхан уулын байгалийн унаган төрх, ургамал амьтны аймгийг хамгаалах, өсгөн үржүүлэх, ан амьтныг нутагшуулах үйл ажиллагаа явуулна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 22 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 228,868.7 мянган төгрөгөөс тооцон 4,577.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцоход материаллаг байдлын түвшин 12,540.2 мянган төгрөг байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49,156.2 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	20,828.0	4,000.0	-16,828.0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	80,792.5	148,088.9	67,296.4
Үндсэн хөрөнгө	616,300.3	614,988.1	-1,312.2
Нийт хөрөнгө	717,920.8	767,076.9	49,156.2
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	717,920.8	763,076.9	45,156.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	717,920.8	767,076.9	49,156.2

Авлага дансны үлдэгдэл буурсан нь 2017 онд цагдаагийн байгууллагад хураагдсан 10,780.0 мянган төгрөг, найдваргүй авлагад 10,000.0 мянган төгрөг, 48.0 мянган төгрөг дансны бичилтийн зөрүү эдгээрийг холбогдох байгууллагаас үндсэн баримтыг авч тайлант онд залруулсан.

БОУАС-гаас 2019 оны 9 дүгээр сарын 17-нд 4,000.0 мянган төгрөгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх, нэр данс зөрүүтэй орлого орж ирснийг буцааж шилжүүлэхгүйгээр Улсын төсөвт төвлөрүүлснээс Сангийн яамнаас авах авлагаар бүртгэж залруулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь хангамжийн материал, биологийн хөрөнгө, мал амьтад өссөнөөс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд оны эцэст 66,200.0 мянган төгрөгийн мал амьтдыг нас дэвшүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар”-ын 2019 оны 10 дугаар сарын 10-ны 387 дугаар тогтоолоор тус бүр нь 15,800.0 мянган төгрөгийн 2 суудлын автомашиныг 800.0 мянган төгрөгөөр дуудлага худалдаагаар худалдсантай холбоотой.

“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар”-ын 2019 оны 10 дугаар сарын 10-ны 389 дугаар тогтоолоор 4 автомашины гараж 4,659.6 мянган төгрөгийн, аж ахуйн хашаа 1,983.8 мянган төгрөгийн, нийт 6,643.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа тайлант онд 20,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 168,073.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 840.4 хувиар биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 148,073.2 мянган төгрөгөөр давсан нь байгаль хамгаалах, нөхөн сэргээх орлого 114,588.2 мянган төгрөг, гэрчилгээний үнэ 22.5 мянган төгрөг, нэвтрэх цэгийн орлого 13,011.2 мянган төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 20,451.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 406,782.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 386,782.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 20,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд урсгал зардлын батлагдсан төсвийн гүйцэтгэл 404,469.2 мянган төгрөг буюу 99.4 хувийн хэмнэлт гарсан байна. Үүнээс 31,551.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

2019 онд Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого нийт 121,185.3 мянган төгрөгийг бүрдүүлжээ.

Үүнээс Бичиг хэргийн зардалд 4,500.3 мянга, тээвэр шатахууны зардалд 8,000.0 мянга, шуудан холбооны зардалд 1,300.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлд 1,500.0 мянга, нормын хувцас, зөөлөн эдлэлд 18,694.5 мянга, багаж, техник хэрэгсэлд 12,000.0 мянга, урсгал засвар 5,992.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 67,134.2 мянга, нийт 119,121.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,063.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ. Үүнээс үнэлэхэд 3 асуудлыг алдаа зөрчилтэйд тооцож, 10 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитаар нийт 36,984.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 34,558.9 мянган төгрөгийн аудитын явцад залруулга, 2,426.0 мянган төгрөгийн алдаа зөрчил арилгуулах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2019 оны 09 дүгээр сарын 03-нд ашиглалтанд орсон MITSUBISHI L200 маркийн 73-09 УАА дугаартай цагаан өнгийн ачааны автомашиныг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас үнэ төлбөргүй хүлээн авсныг тайланд тусгасан эсэхийг авч үзэх, 2019 оны 12 дугаар сард энэхүү машинтай холбоотой нийт 3,440.0 мянган төгрөгийн зардал гарсан байна.

Тус хамгаалалтын захиргааны батлагдсан орон тоо 34, гүйцэтгэлээр ажиллагчдын тоо 26 байна.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй ба авлагыг барагдуулахаар шүүхэд хандсан байна.

Шатахууны талоныг жилийн эцэст их хэмжээгээр нөөцөлж, зарцуулалт болон анхан шатны баримтуудыг хянахад дараа онд хэрэгжсэн нь анхаарал татах асуудал байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь мэдээлж байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 34,423.0 мянган төгрөгийн зөрчилд 1,323.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг барагдуулж, 33,100.0 мянган төгрөгийн зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Залилангийн эрсдэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус хамгаалалтын захиргаа нь тайлант онд 121.8 мкв үйлчилгээний байрандаа хандив тусламжаар 5,730.9 мянган төгрөгийн засвар хийсэн нь баримтын бүрдэл дутуу бүртгэл тайлагналд тусгагдаагүй, мөн урсгал засварын зардлын нийт 1,981.8 мянган төгрөгийн гүйлгээг бүрдэл дутуу баримтаар бүртгэлд тусгасан байна.

Энэ нь “Үнэн зөв байх болон иж бүрэн байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Дээд шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандив авсан байх, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Тайлант хугацаанд орж ирсэн хандив тусламжийг тайлан бүртгэлд тусгаагүйгээс цаашлаад залилангийн эрсдэл үүсэх, баримтгүй болон баримтын иж бүрдэлгүй ажил гүйлгээг тайланд тусгаснаар бодитоор гараагүй зарлагыг бүртгэл тайланд тусгах, хуурамч баримт бүрдүүлэх төсвийн зардлыг зохистой зарцуулахгүй.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн тухай хуулийн 25.4.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 55.3 дахь хэсэгт заасныг, Төсвийн тухай хууль 5 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасныг мөрдөж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны захирлын 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Б тушаалаар 15 байгаль хамгаалагч нарыг ажлаас чөлөөлсөн боловч эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй болно. Жилийн эцсээрх тооллогыг 2020 оны 01 дүгээр сарын 28 ны өдөр хийсэн.

Энэ нь “Иж бүрэн байх болон тасалбар болголт” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2-т "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Тооллого тооцоог хугацаанд нь үнэн зөв хийдэггүй байх, эд хариуцагч солигдох үед хийгээгүйгээс үүдэн хөрөнгө дутах, эд хариуцагч тодорхойгүй байх эрсдлийг учруулж байна.

2.3. Өгсөн зөвлөмж:

Тооллогыг цаг тухайд нь хийж байх, эд хөрөнгө хариуцагч солигдсон үед хүлээн авч бүртгэл тайланд тусгах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 12.2.2-т заасныг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Ажлаас халагдсан байгаль хамгаалагч нар нь хажуу ам хариуцсан, зэргэлдээ байгаль хамгаалагч нар дээр зарим эд хөрөнгийг хариуцуулан хүлээлгэж өгснөөс бага зэргийн хөдөлгөөн гарсныг тулган баталгаажуулахад дутагдаагүй, няравын эд хөрөнгийн карт хөтлөлт дээр бага зэргийн алдаа гарсан байна. Цаашид засаж залруулна.

3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.1. Илрүүлэлт:

Шатахууны зардлыг 2019 оны 1,2, 12 дугаар саруудад 444.2 мянган төгрөгөөр норм, нормативаас илүү зарцуулсан байна.

Энэ нь “Үнэн зөв байх батламж” мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Дэд бүтцийн сайдын 2004 оны “Жишиг норм батлах тухай” 2004 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 19 дүгээр тушаалыг баримтлахгүй байна.

3.2. Эрсдэл:

Тээвэр шатахуун, нормативт зардлыг батлагдсан төсвөөс үндэслэлгүй хэтрүүлэн зарцуулсан байх, илүү зарцуулсан шатахуун нь байгууллагад төлөвлөгөөгүй зардал гаргаж, зардлыг өсгөх

3.3. Өгсөн зөвлөмж:

Шатахууныг жишиг норм, нормативын дагуу хянан зарцуулах, автомашины засвар үйлчилгээ, үзлэгийг хийлгэж байх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Шатахууны жишиг нормын дагуу зарцуулсан боловч, автомашины засвар үйлчилгээ муудсанаас норм, нормативаас илүү шатахуун зарцуулсан харагдаж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>101,620,462.15</u>	<u>152,088,867.15</u>
33	АВЛАГА	20,828,000.00	4,000,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	4,000,000.00
335	Бусад авлага	20,828,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	20,828,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	80,792,462.15	148,088,867.15
354	Хангамжийн материал	57,642,462.15	83,588,867.15
35410	Бичиг хэргийн материал	4,649,454.00	4,292,068.00
35420	Аж ахуйн материал	8,764,824.20	10,192,209.20
35430	Сэлбэг хэрэгсэл	-	4,105,000.00
35440	Түлш, шатах тослох материал	908,500.00	7,655,500.00
35470	Бусад хангамжийн материал	43,319,683.95	57,344,089.95
35500	Биологийн хөрөнгө	23,050,000.00	63,000,000.00
35600	Мал амьтад	100,000.00	1,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>616,300,302.07</u>	<u>614,988,121.66</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	616,300,302.07	614,988,121.66
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	356,354,302.07	355,042,121.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	222,027,000.00	217,772,993.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,992,749.84	-12,990,050.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	125,687,250.00	97,389,250.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-90,400,447.81	-69,568,589.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	74,112,540.88	104,415,313.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32,760,410.49	-45,744,205.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,366,284.43	29,284,093.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,052,415.40	-5,631,113.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	74,244,694.80	70,794,694.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17,877,444.50	-30,680,264.02
393	Биет бус хөрөнгө	259,946,000.00	259,946,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	259,946,000.00	259,946,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>717,920,764.22</u>	<u>767,076,988.81</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>4,000,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,000,000.00
413	Өглөг	-	4,000,000.00
4136	Бусад өглөг	-	4,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	4,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>717,920,764.22</u>	<u>763,076,988.81</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	717,920,764.22	763,076,988.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	721,519,092.36	721,519,092.36
51101	Өмч: - төрийн	721,519,092.36	721,519,092.36
51210	Өмнөх үеийн үр дүн	-29,387,543.16	-39,122,543.16
51220	Тайлант үеийн үр дүн	-	55,156,224.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,789,215.02	25,524,215.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>717,920,764.22</u>	<u>767,076,988.81</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	566,739,084.72	682,165,504.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,015,284.72	295,383,004.89
120	Нийтлэг татварын бус орлого	52,015,284.72	275,465,195.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,065,284.72	275,465,195.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,000,000.00	159,595,180.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,065,284.72	115,870,015.78
120009	Бусад орлого	1,950,000.00	-
122	Тусламжийн орлого	-	19,917,809.11
122001	Хандив тусламж /дотоод/	-	19,917,809.11
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	514,723,800.00	386,782,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	361,088,800.00	386,782,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	361,088,800.00	386,782,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	153,635,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,560,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,075,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	576,412,548.76	594,765,863.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	576,412,548.76	594,765,863.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	496,188,568.66	545,749,344.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,890,657.62	313,945,106.42
210101	Үндсэн цалин	209,801,057.62	271,629,906.42
210102	Нэмэгдэл	53,081,600.00	33,189,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,008,000.00	9,126,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,745,600.00	39,830,038.33
210201	Тэтгэврийн даатгал	22,499,523.68	27,208,528.37
210202	Тэтгэмжийн даатгал	2,811,519.58	3,155,378.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,249,215.06	2,524,302.39
210204	Ажилгүйдлийн даатгал	562,303.52	631,076.10
210205	Эрүүл мэндийн даатгал	5,623,038.16	6,310,752.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,089,556.77	4,509,975.80
210301	Гэрэл, цахилгаан	2,723,456.77	2,598,700.00
210302	Түлш, халаалт	1,953,600.00	1,003,775.80
210303	Цэвэр, бохир ус	412,500.00	907,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,749,981.11	28,630,836.69
210401	Бичиг хэрэг	5,807,746.00	7,229,886.00
210402	Тээвэр, шатахуун	12,860,000.00	6,330,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,786,105.51	2,008,615.69
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,943,563.60	2,386,735.00
210408	Бараа материал ақталсны зардал	8,352,566.00	10,675,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	621,000.00	3,333,800.00
210604	Урсгал засвар	621,000.00	3,333,800.00
2107	Томилолт, зочны зардал	3,654,000.00	3,012,000.00
210702	Дотоод албан томилолт	3,654,000.00	3,012,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,855,000.00	84,483,325.00

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,858,000.00	81,233,159.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	812,000.00	784,836.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	799,900.00	795,230.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	185,100.00	185,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,582,773.16	68,004,262.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,678,200.00	14,016,674.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,904,573.16	53,987,588.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,223,980.10	49,016,518.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,888,234.00	15,401,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,888,234.00	15,401,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,335,746.10	33,614,618.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,335,746.10	33,614,618.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-9,673,464.04	87,399,641.47
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	52,175,576.09	32,243,416.88
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	250,000.00	6,643,416.88
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	25,600,000.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	51,925,576.09	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-52,175,576.09	-32,243,416.88
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-61,849,040.13</u>	<u>55,156,224.59</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>535,723,800.00</u>	<u>557,205,680.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,000,000.00	170,423,180.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,000,000.00	170,423,180.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,000,000.00	170,423,180.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,000,000.00	170,423,180.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	514,723,800.00	386,782,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	361,088,800.00	386,782,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	361,088,800.00	386,782,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	153,635,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,560,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,075,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>530,561,800.00</u>	<u>557,205,680.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	530,561,800.00	557,205,680.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,337,819.90	508,189,161.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,890,657.62	315,911,844.75
210101	Үндсэн цалин	209,801,057.62	232,255,044.75
210102	Нэмэгдэл	53,081,600.00	66,378,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,008,000.00	17,278,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,745,600.00	37,863,300.00
210201	Тэтгэврийн даатгал	22,328,200.00	25,747,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,854,400.00	3,029,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,283,400.00	2,423,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	570,900.00	605,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,708,700.00	6,058,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,089,556.77	4,509,975.80
210301	Гэрэл, цахилгаан	2,723,456.77	2,598,700.00
210302	Түлш, халаалт	1,376,100.00	1,003,775.80
210303	Цэвэр, бохир ус	990,000.00	907,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,474,005.51	24,075,415.69
210401	Бичиг хэрэг	5,277,000.00	5,783,900.00
210402	Тээвэр, шатахуун	9,925,000.00	12,877,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,105.51	3,308,615.69
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,255,900.00	2,105,900.00
2105	Нормативт зардал	-	18,694,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	18,694,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,121,000.00	19,179,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	12,000,000.00
210604	Урсгал засвар	1,121,000.00	7,179,800.00
2107	Томилолт, зочны зардал	3,654,000.00	3,012,000.00
210702	Дотоод албан томилолт	3,654,000.00	3,012,000.00

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,535,000.00	84,942,325.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	77,538,000.00	81,692,159.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	812,000.00	784,836.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	799,900.00	795,230.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	185,100.00	185,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,828,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,828,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,223,980.10	49,016,518.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,888,234.00	15,401,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,888,234.00	15,401,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,335,746.10	33,614,618.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,335,746.10	33,614,618.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,162,000.00</u>	≡
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	25,990,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,990,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	25,990,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,990,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-25,990,000.00</u>	≡
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-20,828,000.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,828,000.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	461,573,092.36	22,754,550.69	32,461,496.97	516,789,140.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	461,573,092.36	22,754,550.69	32,461,496.97	516,789,140.02
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	259,946,000.00	-	-61,849,040.13	198,096,959.87
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	721,519,092.36	25,789,215.02	-29,387,543.16	717,920,764.22
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-9,735,000.00	-9,735,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	721,519,092.36	25,789,215.02	-39,122,543.16	708,185,764.22
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-265,000.00	-	-265,000.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	55,156,224.59	55,156,224.59
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	721,519,092.36	25,524,215.02	16,033,681.43	763,076,988.81

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	406,782,500.00	404,469,222.24	-2,313,277.76	99.4
УРСГАЛ ЗАРДАЛ	406,782,500.00	404,469,222.24	-2,313,277.76	99.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	391,380,600.00	389,067,322.24	-2,313,277.76	99.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	317,936,600.00	315,911,844.75	-2,024,755.25	99.4
Үндсэн цалин	232,549,800.00	232,255,044.75	-294,755.25	99.9
Нэмэгдэл	66,378,800.00	66,378,800.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	19,008,000.00	17,278,000.00	-1,730,000.00	90.9
Гэрээт ажлын хөлс	-	-	-	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,863,300.00	37,863,300.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	25,747,000.00	25,747,000.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	3,029,200.00	3,029,200.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	2,423,200.00	2,423,200.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	605,800.00	605,800.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	6,058,100.00	6,058,100.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,664,800.00	4,509,975.80	-154,824.20	96.7
Гэрэл, цахилгаан	2,598,700.00	2,598,700.00	-	100.0
Түлш, халаалт	1,076,100.00	1,003,775.80	-72,324.20	93.3
Цэвэр, бохир ус	990,000.00	907,500.00	-82,500.00	91.7
Хангамж, бараа материалын зардал	8,789,400.00	8,775,115.69	-14,284.31	99.8
Бичиг хэрэг	1,283,600.00	1,283,600.00	-	100.0
Тээвэр, шатахуун	4,880,300.00	4,877,000.00	-3,300.00	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,019,600.00	2,008,615.69	-10,984.31	99.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	605,900.00	605,900.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,188,000.00	1,187,000.00	-1,000.00	99.9
Урсгал засвар	1,188,000.00	1,187,000.00	-1,000.00	99.9
Томилолт, зочны зардал	3,049,900.00	3,012,000.00	-37,900.00	98.8
Дотоод албан томилолт	3,049,900.00	3,012,000.00	-37,900.00	98.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,888,600.00	17,808,086.00	-80,514.00	99.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,606,600.00	14,557,920.00	-48,680.00	99.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,485,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	812,000.00	784,836.00	-27,164.00	96.7
Тээврийн хэрэгслийн татвар	799,900.00	795,230.00	-4,670.00	99.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	185,100.00	185,100.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,401,900.00	15,401,900.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	15,401,900.00	15,401,900.00	-	100.0

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,401,900.00	15,401,900.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	406,782,500.00	523,304,522.20	116,522,022.20	128.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	386,782,500.00	355,231,342.20	-31,551,157.80	91.8
Улсын төсвөөс санхүүжих	386,782,500.00	355,231,342.20	-31,551,157.80	91.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,000,000.00	168,073,180.00	148,073,180.00	840.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	168,073,180.00	148,073,180.00	840.4
АЖИЛЛАГСАДЫН ТОО	35	35	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	29	29	-	100.0
Үйлчлэх ажилтан	5	5	-	100.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	121,185,300.00
УРСГАЛ ЗАРДАЛ	121,185,300.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,121,839.00
Хангамж, бараа материалын зардал	15,300,300.00
Бичиг хэрэг	4,500,300.00
Тээвэр, шатахуун	8,000,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,300,000.00
Ном, хэвлэл	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00
Нормативт зардал	18,694,500.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,694,500.00
Эд хогшил, урсгал засварын зардал	17,992,800.00
Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00
Урсгал засвар	5,992,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,134,239.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,134,239.00
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,063,461.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,063,461.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	2,063,461.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,350,000.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,350,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,350,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.21	Аудитын нэр: Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/108/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тус хамгаалалтын захиргаа нь тайлант онд 121.8 мкв үйлчилгээний байрандаа хандив тусламжаар 5,730.9 мянган төгрөгийн засвар хийсэн нь баримтын бүрдэл дутуу бүртгэл тайлагналд тусгагдаагүй, мөн урсгал засварын зардлын нийт 1,981.8 мянган төгрөгийн гүйлгээг бүрдэл дутуу баримтаар бүртгэлд тусгасан байна.	1,981.8	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Батмөнх С.Одончимэг
2	Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны захирлын 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Б тушаалаар 15 байгаль хамгаалагч нарыг ажлаас чөлөөлсөн боловч эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй болно. Жилийн эцсээрх тооллогыг 2020 оны 01 дүгээр сарын 28 ны өдөр хийсэн.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	С.Одончимэг
3	Шатахууны зардлыг 2019 оны 1,2, 12 дугаар саруудад 444.2 мянган төгрөгөөр норм, нормативаас илүү зарцуулсан байна.	444.2	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	С.Одончимэг
	Дүн	2426.0			

ТЭМДЭГЛЭЛ

Dotted lines for writing

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines intended for writing conclusions.

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing.